



Хичээлийн сэдэв: ТӨР ЭДИЙН ЗАСГИЙГ ЯМАР БОДЛОГООР ЗОХИЦУУЛДАГ ВЭ?



Хичээлийн зорилго

❑ Сангийн бодлого, мөнгөний бодлого тэдгээрийн арга хэрэгсэл, ач холбогдлыг баримт мэдээлэлд үндэслэн тодорхойлох

❑ Нийт эрэлтийн бүтцийг нэрлэнэ үү.

❑ Дараах тохиолдлуудыг зөв харгалзуулна уу.

Өрх гэрийн хэрэглээний зардал

Аж ахуйн нэгжийн зардал

Төрийн зардал

Гадаадын хэрэглэгчийн зардал

Сүү ХК үнээний ферм байгуулсан

Бат гэртээ талх, мах, гурил худалдаж авсан

“Говь ХК” ноолууран бүтээгдэхүүнээ Европын орнууд руу гаргасан

Орон нутгийн төсвөөс 100 км зам тавьж ашиглалтад оруулсан



Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй тиймээс төрийн оролцоотойгоор **нийт эрэлтийг** нэмэгдүүлэх замаар энэ зорилтыг шийдэх ёстой.

Ж.Кейнс




1929 оны 10 дугаар сарын 29-ний хямралыг хамгийн удаан үргэлжилсэн гэж үздэг. Үүнийг түүхэнд “Хар мягмар” гариг гэж нэрлэдэг.



Америкийн Ерөнхийлөгчөөр Франклин Рузвельт сонгогдмогцоо “Төрийн эдийн засаг дахь оролцоо, зохицуулалт хийх” гэсэн Кейнсийн онолыг хэрэгжүүлэв.

ТӨР ЭДИЙН ЗАСГИЙГ ЯМАР БОДЛОГООР ЗОХИЦУУЛДАГ ВЭ?



Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг **төрийн сангийн (төсвийн) бодлого** гэнэ.



Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг **төрийн мөнгө, зээлийн бодлого** гэнэ.

ОРЛОГО



ЗАРЛАГА



ХОМСДОЛ

ОРЛОГО



ЗАРЛАГА



ИЛҮҮДЭЛ

Сангийн бодлого

```
graph TD; A[Сангийн бодлого] --> B[Төсвийн зарлагыг нэмэгдүүлэх]; A --> C[Төсвийн орлогыг бууруулах]; B --> D[Нийтийн шинжтэй ажил зохион байгуулах]; B --> E["“Засгийн газрын хөтөлбөр” хэрэгжүүлэх"]; B --> F[Татварын хэмжээг бууруулах];
```

Төсвийн
зарлагыг
нэмэгдүүлэх

Төсвийн орлогыг
бууруулах

Нийтийн
шинжтэй ажил
зохион байгуулах

“Засгийн газрын
хөтөлбөр”
хэрэгжүүлэх

Татварын
хэмжээг
бууруулах

1. САНГИЙН БОДЛОГО

?

Улсын зардлыг нэмэгдүүлэх нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

1

Төр өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил зохион байгуулж болно.

2

Төрөөс “Засгийн газрын хөтөлбөр, төсөл” боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд зориулж зардлаа ихэсгэж болно

?

Татварын дарамтыг багасгах нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

1

Хувь хүн болон аж ахуйн нэгжээс авах татварын хэмжээг бууруулснаар хэрэглэгчийн орлого, аж ахуйн нэгжийн орлого өснө



САНГИЙН
ЯАМ



?

Энэ мэдээний агуулга төрийн сангийн ямар, ямар бодлогыг илэрхийлж байна вэ?



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрсөн амралтын өдрүүдээр Дорноговь аймагт ажиллаж **Тавантолгой-Зүүнбаян** чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцлаа. “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-д тусгагдсаны дагуу баригдаж буй 414.6 км төмөр замын ажил Дорноговь аймгийн Мандах, Зүүнбаян гэсэн хоёр суманд зэрэг үргэлжилж байгаа юм. Ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний жанжин штаб, туслан гүйцэтгэгчээр одоогийн байдлаар дотоодын **15 аж ахуйн нэгж** ажиллаж байна.

Эх сурвалж: <https://president.mn/10906/>



Засгийн газрын тогтоолоор

- автобензинд ногдуулах онцгой албан татварыг **160** мянган төгрөгөөс **50** мянган төгрөг болгож,/ **90**-ээс дээш октантайг **160** мянган төгрөгөөс **30** мянган төгрөг/,
- дизелийн түлшинд ногдох татвар **180** мянган төгрөг байсныг **70** мянган төгрөг болгон бууруулж тогтоолоо. Ингэснээр улсын төсвийн орлого **110** орчим тэрбум төгрөгөөр буурах ч, шатахууны үнийн өсөлтийг саармагжуулах боломжтой гэж холбогдох яам болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын холбоо үзэж байгаа юм.

Эх сурвалж: <http://www.olloo.mn/n/38276.html>

2. МӨНГӨ, ЗЭЭЛИЙН БОДЛОГО



МӨНГӨ, ЗЭЭЛИЙН БОДЛОГО

- Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор **мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд** нөлөөлөх бодлого

Төр нийт эрэлтийг нэмэгдүүлж эдийн засгийн уналтыг сааруулахын тулд **зээлийн хүүг бууруулах**, эсвэл гүйлгээнд байх ёстой **мөнгөний тоо хэмжээг өсгөх** механизмыг хэрэглэж болно.

?

Зээлийн хүүг бууруулах нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

- ✓ Банкны зээлийн хүү буурахад иргэд болон аж ахуй нэгжүүдээс хэрэглээ болон хөрөнгө оруулалтдаа зориулж зээлийн хэмжээ нэмэгдэж гүйлгээнд байх мөнгөний тоо хэмжээ өссөнөөр хүмүүс мөнгөтэй болж нийт эрэлт нэмэгдэнэ.

?

Гүйлгээнд байх мөнгөний тоо хэмжээг өсгөх нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ?

- ✓ Эдийн засагт мөнгөний хэмжээг түүний хэрэгцээнээс хамааруулаад өсгөөд байвал хүмүүсийн хувьд мөнгөний үнэ цэн буурч тэд мөнгийг хадгалахын оронд бараагаар солихыг илүүд үзнэ. Аль болох бага хуримтлуулж илүү ихийг худаадан авснаар нийт эрэлтийг нэмэгдүүлнэ гэж үздэг.

Зээлийн хүүгийн тусламжтайгаар гүйлгээнд мөнгөний нийлүүлэлтийг зохицуулна

Мөнгөний хумих
бодлого

- Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлого

Мөнгөний тэлэх
бодлого

- Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого





Сангийн бодлого

Эдийн засгийн
өсөлтийг
урамшуулна


Инфляцийн
эсрэг хүчин
мөхөсддөг

Мөнгө, зээлийн бодлого


Инфляцид
хүчтэй нөлөө
үзүүлж чаддаг

Илүү уян хатан
чанартай
байдаг

Төрийн эдийн
засгийн бодлогын
арга хэмжээнүүд
нь ямагт нийгмийн
нэг бүлгийнхний
сонирхолд нийцэж,
нөгөө хэсгийнхний
сонирхолтой
зөрчилдөж байдаг.



Джон Мейнард Кейнс (1883-1945)



Фридрих фон Хайек (1899-1992)



☐ Кейнсийг эдийн засгийн ухаан хувьсгал хийсэн гэж үздэг

☐ Төрийн оролцоотойгоор эдийн засгийн үр өгөөжтэй байдлыг хангаж болно

☐ Эх орныхоо өмнө байгуулсан гавьяаг нь үнэлэн түүнд “Лорд” зэрэг олгожээ



☐ Хэнд ч төрд ч эдийн засгийг удирдах шаардлагатай бүх мэдээлэл байдаггүй

☐ Иймээс эдийн засгийг үр ашигтай удирдах боломжгүй

☐ 1974 онд түүнд Нобелийн шагнал олгожээ

1. Английн эрдэмтэн М.Кейнс эдийн засгийн уналт болон ажилгүйдлийн шалтгааныг эдийн засгийн ямар ойлголттой холбон тайлбарласан байдаг вэ?

- A. Нийт нийлүүлэлт
- B. Нийт эрэлт**
- C. Мөнгөний бодлого
- D. Эдийн засгийн үр өгөөж
- E. Эдийн засгийн ашиг

2. Монгол улсын сангийн бодлогыг хариуцаж байдаг төрийн байгууллагыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Төв банк
- B. Сангийн яам**
- C. Санхүүгийн зохицуулах хороо
- D. Гадаад явдлын яам
- E. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын

газар

3. Засгийн газрын хөтөлбөр боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд зориулж төр зардлаа ихэсгэдэг. Энэ нь төрийн эдийн засгийн ямар бодлого вэ?

- A. Төрийн сангийн бодлого**
- B. Мөнгө, зээлийн бодлого
- C. Гадаад худалдааны бодлого
- D. Татварын бодлого
- E. Хөрөнгө оруулалтын бодлого

4. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлогыг ямар бодлого гэдэг вэ?

- A. Мөнгөний тэлэх
- B. Мөнгөний хумих**
- C. Засгийн газрын
- D. Сангийн яамны
- E. Эдийн засгийн



Гэрийн даалгавар




Улаанбаатар хот
2018 он

Та бүхэн сурах бичгийнхээ 107-114 дээр хуудсан дээр буй мэдээллийг уншаарай.

- Мэдээллийг унших явцдаа гол ойлголтуудыг тэмдэглэж аваарай.
- Сурах бичгийн асуулт даалгаврыг гүйцэтгэж багшаасаа зөвлөгөө аваарай.

Хичээлийн агуулгатай холбоотой мэдээллийг дараах сайтуудаас илүү дэлгэрүүлэн бие дааж судлах боломжтой. Үүнд:

- ☐ <https://mof.gov.mn/>
- ☐ <https://www.mongolbank.mn/>
- ☐ <https://www.1212.mn/>



Хичээлийн сэдэв:

ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО



Хичээлийн зорилго

- ❑ Гадаад худалдааны төрөл, онцлог, ач холбогдлыг статистик тоо баримт ашиглан тайлбарлах





Улс орон бүр өөрсдийн хэрэглэх зүйлээ өөрсдөө үйлдвэрлэж болохгүй гэж үү?

- ✓ Хүний хэрэгцээт бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох нөөц, ажиллах хүч, капитал улс орон бүрт харилцан адилгүй өөр өөр байдагтай холбоотой.



Экспорт, импорт нь улс орны хувьд ямар ач холбогдолтой вэ?

- ✓ Экспортын өсөлт нь эх орны бүтээгдэхүүний хувьд зах зээлийг өргөтгөж байгаа тул тухайн улс орны хувьд ашигтай. Импорт нь тухайн орны хэрэглэгчдэд ашигтай нөхцлийг бий болгодог.





ЭКСПОРТ **ОРЛОГО**, ИМПОРТ **ЗАРДЛЫГ** ИЛЭРХИЙЛНЭ.
ЭКСПОРТЫН ОРЛОГООС ИМПОРТЫН ЗАРДЛЫГ ХАСАЖ, ГАДААД
ХУДАЛДААНЫ АШИГ АЛДАГДЛЫГ ТОДОРХОЙЛНО.
ЭКСПОРТ ИМПОРТЫН ЗӨРҮҮГ ГАДААД ХУДАЛДААНЫ **ТЭНЦЭЛ** ГЭНЭ.





Экспорт импортын нийлбэрийг гадаад худалдааны
барааны **НИЙТ ЭРГЭЛТ** гэнэ.

Дараах онуудын гадаад худалдааны нийт бараа эргэлт болон гадаад худалдааны тэнцлийг хамтран тодорхойлцгооё. (сая. ам.доллар)

№	Үзүүлэлт	2007	2008	2010	2012	2014	2016
1	Нийт эргэлт	3962.3	5578.5	6108.9	11123.1	11011.0	8274.4
2	Нийт экспорт	1945.5	2534.5	2908.5	4384.7	5774.3	4916.3
3	Нийт импорт	2016.8	3244.5	3200.1	6738.4	5236.7	3358.1
4	Гадаад худалдаа +ашиг, - алдагдал	-71.3	-710.0	-291.6	-2353.7	5376.6	1.558.2

Гадаад худалдааны тэнцэл, оноор, тэрбум ам.доллар





Доорх мэдээллээс ямар, ямар дүгнэлт хийж болох вэ?

Экспорт 2019 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 43%-иар буюу 183 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 42 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.1 хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.8 нэгж хувиар буурсан байна.

Импорт 2019 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 40%-иар буюу 143 сая ам.доллараар өсөв. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 24 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 9 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

<https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2019/01.pdf>



Туйлын давуу талын онол

- Дулаан уур амьсгалтай орнууд жимсийг, нефтээр баян орон нефтийг, аж үйлдвэр хөгжсөн орнууд аж үйлдвэрийн барааг экспортолдог болохыг энэ онолоор тайлбарлаж болно.



Харьцангуй давуу талын онол

- Хэрэв А улс Б улстай харьцуулахад нөөцийн хамгийн бага зардлаар үйлдвэрлэдэг бол тэр нь туйлын давуу талтай байгаа хэрэг.
- Гэхдээ тухайн нэг улс бүх төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхдээ туйлын давуу талтай байгаа тэр тохиолдолд ч гэсэн бусад улстай бүтээгдэхүүний солилцоо хийх нь харилцан ашигтай байж болно.

Эзгүй арал дээр Робинзон бид хоёр амьдардаг байлаа гэж бодье. Загас, жимс гэсэн хоёр л төрлийн хүнстэй. Би загас барихдаа Робинзоноос хамаагүй илүү, жимс түүхдээ бид хоёр бараг адил. Тэгвэл хамгийн их хоолтой байхын тулд бид хоёр ажлаа яаж хуваарилах вэ?


Аль алинд нь би илүү ч гэсэн ганцаараа хийснээс хоёулаа хийвэл мэдээж илүү хоолтой болно. Тиймээс би загасаа барьж, Робинзоноор жимс түүлгэх нь хамгийн их хоолтой байх хувилбар юм. Өөрөөр хэлбэл хэн хэнийхээ давуу талд тулгуурлан, өөр өөрийн сайн хийж чаддаг ажлаа хийх нь хоёуланд маань илүү хоолтой байх боломжийг бүрдүүлж байна. Робинзон жимс түүхдээ сайн гэдэг нь харьцангуй давуу тал юм. Харин би жимс түүх, загас барих нь аль алинд илүү гэдэг нь туйлын давуу тал болно.

(Эх сурвалж: Б. Ган-Очир. “Амьд эдийн засаг”)

Гадаад худалдааг ямар бодлогоор зохицуулдаг вэ?

Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогцыг **гадаад худалдааны бодлого** гэж нэрлэнэ.

Аж үйлдвэр нь өрсөлдөх чадвараар сул, хөгжиж байгаа улс орнууд гадаад худалдааны **протекционист бодлогыг** хэрэгжүүлдэг.





ҮЙЛДВЭРЛЭГЧИД ГАДААДЫН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХИЙН
ТУЛД ӨРСӨЛДӨГЧӨӨСӨӨ ДООГУУР ҮНЭЭР БАРААГАА
ШАХАЖ ДАРАА НЬ ҮНЭЭ ӨСГӨХ ЗОРИЛГОТой ТҮР
ЗУУРЫН ҮЗЭГДЭЛ



Чөлөөт худалдааны бодлого

Энэ нь протекционист бодлогын эсрэг бодлого юм. Гадаад худалдаанд төр оролцох ёсгүй, төр нь чөлөөт зах зээлийн жамаар тухайлбал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, өрсөлдөөний хуулиар хөгжих ёстой гэсэн зарчмыг баримталдаг учраас татварыг бууруулах, бусад хязгаарлалтуудыг үгүй болгоход чиглэгддэг.

1. Нөхөж бичнэ үү? Олон улсын худалдаа гэдэг нь.....хэлнэ.

A. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудад борлуулахыг хэлнэ.

B. Экспорт, импортын зөрүүг хэлнэ.

C. Экспорт, импортын нийлбэрийг хэлнэ.

D. Улс орон хоорондын бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөнийг хэлнэ.

E. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудаас худалдаж авахыг хэлнэ.

2. Нөхөж бичнэ үү? Гадаад худалдааны тэнцэл гэдэг нь хэлнэ.

A. Экспорт, импортын зөрүүг хэлнэ.

B. Экспорт, импортын нийлбэрийг хэлнэ.

C. Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөнийг хэлнэ.

D. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудад борлуулахыг хэлнэ.

E. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудаас худалдаж авахыг хэлнэ.

3. Монгол оронд усан үзэм тариалахад гарах зардал БНХАУ-д тариалснаас өндөр гарах нь ойлгомжтой. Учир нь Монголд усан үзмийг зөвхөн хүлэмжинд ургуулах боломжтой. Харин Хятадын зөөлөн дулаан уур амьсгалтай өмнөд нутгийн задгай хөрсөнд бараг зөнгөөрөө ургана. Үүнийг гадаад худалдааны ямар онолоор тайлбарлаж болох вэ?

A. Хөрөнгө оруулалтын онол

B. Протекционист онол

C. Туйлын давуу талын онол

D. Тарифийн хязгаарлалт

E. Квотын хязгаарлалт

Өнөөдрийн хичээлийн гол ойлголтуудыг зөв харгалзуулья

Экспорт

Импорт

Протекционизм

Импортын татвар

Импортын хязгаарлалт

Демпинг

Чөлөөт худалдаа

Чөлөөт худалдаанд хязгаарлалт тавих

Импортлож байгаа бараанд ногдуулах татвар

Бусад орны иргэд болон ААН-үүдээс бидний худалдан авч байгаа бараа, үйлчилгээ

Бусад орноос оруулж ирж байгаа барааны тоо хэмжээнд тавих хязгаарлалтууд

Барааг гадаадын зах зээлд өөрийн өртгөөс нь доогуур үнээр худалдах

Төрийн ямар нэгэн оролцоогүйгээр олон улсын хоорондын хийгдэх арилжаа

Нэг улс бусад орны иргэд, ААН-үүдэд бараа, үйлчилгээ худалдах

Гэрийн даалгавар



Улаанбаатар хот
2018 он

Та бүхэн сурах бичгийнхээ 115-119 дээр хуудсан дээр буй мэдээллийг уншаарай.

- Мэдээллийг унших явцдаа гол ойлголтуудыг тэмдэглэж аваарай.
- Сурах бичгийн асуулт даалгаврыг гүйцэтгэж багшдаа шалгуулж, зөвлөгөө аваарай.

Хичээлийн агуулгатай холбоотой мэдээллийг дараах сайтуудаас илүү дэлгэрүүлэн бие дааж судлах боломжтой. Үүнд:

<https://mof.gov.mn/>

<https://www.mongolbank.mn/>

<https://www.1212.mn/>

Валютын ханш



Валют: Гадаад, дотоод төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа аль нэг улсын мөнгөн тэмдэгтийг хэлнэ



Валютын ханш

Аль нэг улсын валютыг өөр нэгэн улсын валютаар илэрхийлсэн үнэ юм. Өөрөөр хэлбэл тухайн улсын нэгж валют өөр улсын валютын хэдэн нэгжтэй тэнцэхийг харуулдаг үзүүлэлт юм. Жишээ нь: АНУ-ын 1 ам.доллар = 2427 төгрөг гэх мэт.

Валютын ханш буюу гадаад валютын үнэ уг валютын эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдоно. Жишээлбэл, гадны орон руу аяллаар явах үеэд хэрэглээний бараа бэлэг дурсгалын зүйлс, хоол хүнс, зочид буудлын төлбөр бусад бүтээгдэхүүн худалдан авахад гадаад валют зайлшгүй хэрэг болдог. Энэ нь гадаад валютын эрэлтийг бий болгож буй нэг жишээ юм. Монгол Улсад гадаадын жуулчид ирж ам.доллар эсвэл евро зэрэг гадаад валютаа солиулан бараа бүтээгдэхүүн худалдан авч байгаа нь эсрэгээрээ валютын нийлүүлэлтийг нэмэгдүүлж буй жишээ болно

01 ЧӨЛӨӨТЭЙ ХӨРВӨХ
ЧАДВАРТАЙ

02 ХЯЗГААРЛАГДМАЛ ХӨРВӨХ
ЧАДВАРТАЙ

03 ХӨРВӨХ ЧАДВАРГҮЙ



Тогтмол ханшийн дэглэм

Валютын тогтмол ханшийн дэглэмийн үед тухайн улсын төв банк үндэсний валютын бусад улсын валюттай харьцах ханшийг тогтмол түвшинд барих бөгөөд үүний тулд төв банк нь гадаад валютын хангалттай нөөцтэй байх шаардлагатай.

Валютын ханш
тогтмол байх тул
тодорхой бус байдал
багатай .

S

Мөнгөний бодлогын
бие даасан байдал
алдагддаг

W

Импортын барааны
инфляцийн дарамт
харьцангуй бага

O

Төлбөрийн тэнцэл зах
зээлийн зарчмын
дагуу тэнцвэрждэггүй.

T

ЧӨЛӨӨТЭЙ ХӨВӨГЧ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Чөлөөтэй хөвөгч ханшийн дэглэмийн үед төв банк үндэсний валютын ханшийг зах зээлд чөлөөтэй хэлбэлзэж байхыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд төв банк валютын захад оролцдоггүй.

Төв банк мөнгөний
бодлогоо эдийн засгийн
нөхцөл байдалд
тохируулан хэрэгжүүлэх
боломжтой

S

Валютын зах зээлд
огцом хэлбэлзэл бий
болох эрсдэлтэй

W

Төлбөрийн тэнцэл зах
зээлийн зарчмын дагуу
тэнцвэржих нөхцөл
бүрдэнэ.

O

Валютын ханш
суларснаар импортын
барааны инфляцын
дарамт нэмэгддэг.

T

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХӨВӨХ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмийн үед валютын ханш валютын эрэлт, нийлүүлэлт буюу валютын урсгалаар тодорхойлогдох боловч валютын захад ханшийн огцом хэлбэлзэл бий болсон үед Төв банк хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор гадаад валют худалдах, худалдан авах байдлаар зах зээлд оролцдог.

Зах зээлийн ханшийн өөрчлөлтөд дасан зохицох, хүлээлтээ удирдах боломжийг олгосноор ААН-үүд үйл ажиллагаагаа тогтвортой удирдан явуулах нөхцөлийг бүрдүүлдэг.

S

Төв банк тодорхой хэмжээгээр гадаад валютын нөөцтэй байх шаардлагатай.

W

Мөнгөний бодлого эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлд үр дүнтэй хэрэгжих боломжтой.

O

T

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

1."Гадаадын хөрөнгө оруулалт" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ.



ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

<https://ikon.mn/opinion/1hvk>

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрээ байгуулах эсвэл шууд худалдан авахыг гадаадын шууд хөрөнгө оруулалт гэнэ.

<https://www.youtube.com/watch?v=09FIWwiKqY0>

Портфелийн
хөрөнгө оруулалтыг
гадаадын
компанийг хянах
зорилгоор бус
харин үнэт
цааснаас ногдол
ашиг болон үнэт
цаасны ханшны
өсөлтөөс орлого
олохын тулд хийдэг.



ПОРТФЕЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энэ хэлбэрийн хөрөнгө оруулагчид
үнэт цасны ханш өсөж байгаа
болон хүүгийн хэмжээ өндөр байгаа
орнууд руу тэмүүлдэг. Үнэт цаас
худалдан авагчид ханшны өсөлтөөс
орлого олохыг илүүд үздэг.



ПОРТФЕЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ НЬ КОМПАНИУД
БОЛОН ТУХАЙН УЛСАД
ХӨРӨНГӨ АШИГЛАХ БОЛОМЖ
ОЛГОДОГ УЧРААС КАПИТАЛ
ИМПОРТОЛЖ БАЙГАА ОРОНДОО
АШИГТАЙ. .



ЭНЭХҮҮ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ НЬ УРТ
ХУГАЦААНД, ИЛҮҮ
НАЙДВАРТАЙ БАЙЖ
ЧАДАХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ ЮМ.



ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТТАЙ
ХАРЬЦУУЛАХАД
ХӨРВӨХ ЧАДВАР
ӨНДӨР БАЙДАГ



Үнэт цаас худалдан авагч
тодорхой нэгэн компанийн
үнэт цаасны 10%-иас дээш
хувийг эзэмших боломгүй.

ҮНДЭСТЭН ДАМНАСАН КОРПОРАЦИ

Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай компани юм.

https://www.humanities.mn/fileman/Uploads/MD_lecture/Enkhtsetseg.S/%D0%BB%D0%B5%D0%BA%D1%86%209.pdf